



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 08 өдөр

Дугаар АНЗЗ

Хужирт сум

Бруцеллэз өвчнөөс урьдчилан
сэргийлэх вакцинжуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.6, аймгийн Мал эмнэлгийн 2023 оны “Бруцеллэзийн вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/27 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 09 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтыг дээрх хугацаанд чанартай, үр дүнтэй зохион байгуулж “Бруцеллэз өвчний дархлаажуулалт хийх ажлын удирдамж”-ийг хэрэгжүүлж ажиллахыг “Гонир манал”, “Гуахарз” мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн эмч (Ш.Байгалмаа), (Д.Даваасүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, тарилгын акт жагсаалтад дүгнэлт гарган тайлан мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

622391267

D:Alban bichig;Zahiramj 2023